



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А/198

Булган

Г Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээнд тусгагдсан Үерийн хамгаалалтын суваг, явган хүний замын ажил /Булган, Булган сум, 2 дугаар баг/-ын гүйцэтгэгч сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу "Вэлмот" ХХК-ийг сонгож 539 175 874 /Таван зуун гучин есөн сая нэг зуун далан таван мянга найман зуун далан дөрөв/ төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Ү.Бямбасүрэн/-т олгосугай

2. Дээрх ажлын гүйцэтгэгчтэй холбогдох хууль, журмын дагуу гэрээг байгуулж, гүйцэтгэлд хяналт тавьж, хүлээн авахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /Д.Буманбаяр/, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Ү.Бямбасүрэн/-т даалгасугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг "Вэлмот" ХХК /Г.Баатарцогт/-д үүрэг болгосугай.

4. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль, журам гэрээний дагуу санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Д.Батцогт/-т зөвшөөрсүгэй.

5. Хавсралтад заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусгаж, хяналт тавин ажиллахыг холбогдох байгууллагын дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ

20190204

Аймгийн Засаг даргын 2019 оны 04 сарын 11
өдрийн 1198 дүгээр захирамжийн 1-р хавсралт

№	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн /хувь/	Хариуцах албан тушаалтан
1	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	4,594,338	Ү.Бямбасүрэн
2	Магадлашгүй ажил	9,188,676	Ү.Бямбасүрэн
3	Захиалагчийн албаны зардал	9,188,676	Ү.Бямбасүрэн
4	Инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн	10,000,000	Ү.Бямбасүрэн
5	Орон нутгаас авах ажиллах хүчний тоо	14 хүн	Н.Батжаргал
6	Алданги	Хоногт гэрээний үнийн дүнгийн 0.1 хувь	Д.Батцогт
7	Ажил гүйцэтгэх хугацаа	Гэрээ байгуулснаас хойш 95 хоног	Ү.Бямбасүрэн